

ОРХОНЫ ХАР БАЛГАСААС ОЛДСОН УЙГУРЫН ХААДЫН ЦОЛ ӨРГӨМЖЛӨХ БИЧИГ

Д. Содномжамц¹, У. Эрдэнэбат^{2,*}, К. Франкен³, Т. Батбаяр⁴, Х. Рооланд⁵

Товч агуулга: Археологийн малтлага нь бичгийн эх сурвалжийн судалгааны хамт дундад зууны үеийн талын нүүдэлчдийн эзэнт гүрнүүд, тэдний соёл хоорондын харилцааг илүү сайн ойлгох үндэс суурь болдог. Орхоны хөндийн Хар балгасаас Монгол-Германы Орхон Экспедицийн илрүүлж олсон сонирхолтой бүлэг олдвор бол “Хаш өргөмжлөл” хэмээх сайтар засаж өнгөлсөн, эртний Хятадын уран бичлэгийн тигээр сийлж, сийлсэн үсгүүдэд алт суулгасан бичигтэй цагаан гантгиг чулуун цуудаснууд юм. Эдгээр цуудсыг алтан утсаар холбодог байсан нь Хятадын уламжлалт хулсан бичиг номтой төстэй бөгөөд үнэт чулуун бичээснүүдийг Тан улсын хаан төрөөс чухал үйл хэрэгт зориулан ашигладаг байжээ. Монголын тал нутагт орших дундад эртний Ордубалык хотоос Уйгурын хаадад өмнөд хөршөөс нь илгээсэн цол өргөмжлөл бичгийн хэсгүүд ийнхүү олдсон нь Уйгурын захирагчид Тангийн эзэн хааны ордонтой нягт харилцаа холбоотой байсныг онцолж, Хар балгасын цайзат их хэрмийн Цитаделийг Уйгурын нийслэлийн улс төрийн томоохон ач холбогдолтой газар, магадгүй хааны ордон мөн гэсэн тайлбарыг дэмжиж байна.

Түлхүүр үг: Орхоны хөндий, Уйгурын хаант улс, Ордубалык, Хар балгас, Тан улс, цол өргөмжлөл бичиг

Удиртгал

Монгол Улсын төв нутаг Орхоны хөндийд, Архангай аймгийн Хотонт сумын нутагт орших Уйгурын хаант улсын нийслэл Ордубалык буюу Хар балгасын турьд 2009 оноос хойш Монгол-Германы Орхон Экспедиц (MONDOGrEx) тогтмол малтлага шинжилгээ хийж дундад эртний уран барилгын өвөрмөц зохион байгуулалтыг илрүүлэн судалж байна (Huettel & Erdenebat 2009; Franken et al. 2014; 2017; 2018; Эрдэнэбат, Содномжамц 2016; Toepfer et al. 2023). Хар балгасын цайзат их хэрмийн зүүн урд булангийн өндөр цонж дээрх барилгын чуулбар нь голдоо задгай хүрээтэй, түүний гол төв хэсэгт гүний худагтай байсныг 2018 онд бид олж нээсэн билээ. Археологичид “цитадель” гэж нэрлэдэг энэхүү байгууламж дээр Уйгурын нийслэлийн засаг захиргаа, шүтлэг бишрэлийн чухал газар байрлаж байжээ (Franken et al. 2019; 2020; Rohland et al. 2023). Эндээс малтаж гаргасан хэдэн арван олдворын дотроос дээрээ хятад бичигтэй гантгиг чулууны хугархай хэсгүүд нь Уйгурын улс төрийн гадаад харилцааны түүхийг судлах эрдэм шинжилгээний онцгой ач холбогдолтой бичгийн эх сурвалж болно.

Үүрэг зориулалт болон бичээсийн төрөл

Хар балгасын НВ-2 малтлагын талбайн барилгын нуранги хийгээд худаг дотроос дээрээ ханз үсэгтэй гантгиг чулууны нийт 46 ширхэг хугархай энд тэндээс эмх замбараагүй байдалтай илэрсэн бол нэг ширхэг нь цайзат хэрмийн гадна талаас түүвэр байдлаар олджээ (Зураг 1). Ерөнхий хэлбэрийн хувьд урт нарийн цуудсан хэлбэрийн цагаан өнгийн гантгиг (汉白玉, marble) чулуун дээр эртний хятад ханз үсгийг хичээнгүй бичгийн тэгээр сийлсэн бөгөөд зарим чулуудын дээд болон доод талын хажуугаас нь нэвт нүхэлж хооронд нь хэлхэх зориулалт бүхий сүвлэх нүх гаргажээ. Бичээстэй чулуудыг хотыг мөхөөх үед цөмийг нь зориуд хугачиж хаясан тул дийлэнх нь хоорондоо эвлэхгүй. Зөвхөн 4 хугархай хэсэг л үгийн утга болон хугарч эмтэрсэн хэсгээрээ нийлж байна.

Хар балгасаас олдсон дээрх гантгиг чулуун олдворын хэлбэр дүрсийг хөрш зэргэлдээх бүс нутгуудаас олдсон ижил хэрэглэгдэхүүнтэй харьцуулан үзвэл энэ төрлийн бичээсийг ерөнхийд нь Зарлигийн бичиг (册书-ceshu) хэмээн нэрлэдэг бөгөөд хаш эсвэл гантгиг чулуугаар хийснийг Хаш өргөмжлөл (玉册-yuse) гэнэ. Тан улсын үед уг бичгийг зөвхөн хааны ордноос зарлигийн дагуу тусгайлан эрхлэн гаргаж байсан бөгөөд үүрэг зориулалтаасаа хамаараад дотроо олон төрөлтэй байжээ. Шинээр хаан суух, зарлиг буулгах, цол өргөмжлөл, тахилга үйлдэх, талийгаачид эмгэнэл илэрхийлэх зэрэг зөвхөн хаад язгууртан нарт зориулсан ёслол хүндэтгэлийн үйл ажиллагаанд хэрэглэдэг байжээ (Ren Jiang 2007: 45).

¹ ШУА-ийн Археологийн хүрээлэн

² МУИС, Шинжлэх Ухааны Сургууль, Антропологи, Археологийн тэнхим

* Холбоо барих зохиогч: u_erdenebat@num.edu.mn

<https://orcid.org/0000-0003-0867-3691>

³ Германы Археологийн хүрээлэн, Европоос гадуурх Соёлуудын Археологийн

⁴ ШУА-ийн Археологийн хүрээлэн

⁵ Германы Археологийн хүрээлэн, Европоос гадуурх Соёлуудын Археологийн Комисс

Тан улсаас өөрсдийн хаад, язгууртан нарт цол өргөмжлөхөөс гадна улс төр, эдийн засгийн олон шалтгааны улмаас хөрш зэргэлдээх улсын хаадад цол өргөмжилж байсан мэдээ цөөнгүй бөгөөд судлаачид 2 төрөл болгон ангилсан байдаг. Нэгдүгээр төрөлд хамаарах нь Тангийн төрөөс хэргэм зэрэг хүртэж нөлөөнд нь байх боловч Тан улсын ноёрхлын хүрээнд багтахгүй хөрш зэрэгцэн орших дорнын И (东夷) нар болох Когүрйө (高丽), Пакжэ (百济), Шилла (新罗), өмнөдийн Ман (南蛮)-д Шривижая (尸利佛誓), баруун талд орших өрнийн Рун (西戎) нар болох Баруун Түрэг (西突厥), Тубо (吐蕃), Бружа (勃律), хойд талд Умард Ди (北狄)-д Сеяньто (薛延陀) зэрэг улсуудыг багтаажээ.

Хоёрдугаар төрөлд Тан улсын газар нутгаа тэлэх бодлогын үр дүнд нэг үе Дүдү фү (都督府), Дүхү фү (都护府) гэсэн нэрээр харьяалагдаж байсан боловч хожим Тан улсаас салж бие даан оршин тогтнож засаглах болсон хойд хөрш болох Хожуу Түрэг, Уйгур, Киргиз зэрэг улсууд хамаарна (Wang Yikang 2018: 45). Эдгээр улсын хаад нь Тангийн хаадтай ижил зэрэг дэвийн хэмжээнд цол өргөмжлөгдөж байжээ.

Харин өргөмжлөх бичээстэй хэлбэрийн хувьд төстэй өөр нэг төрлийг нь Эмгэнэх бичиг (哀册- ai ce) хэмээн нэрлэдэг. Эмгэнэх бичгийг хааны угсааны язгууртан хүмүүсийг нас барахад шарилд хамт хийж оршуулдаг бөгөөд урт нарийн хэлбэртэй (27-30 см урт, 2-2,3 см өргөн, 1-1,3 см зузаан) хаш эсвэл гантиг чулуун дээр ханз үсгийг дээрээс доош чиглэлд бичиж, зарим тохиолдолд үсгийг алтаар бүрсэн байдаг (Fan Yingfeng, Bai Genxing 2006: 248, Kaogu 2023: 284). Бичээсийн утгын хувьд ихэвчлэн талийгаачийн амьд ахуй цагтаа хийсэн үйл хэргийн талаар бичиж, түүнийг санан дурсаж эмгэнэн гашуудаж буй байдлаар өгүүлдэг байна.

Хятадаар 哀册 (ai ce) гэж нэрлэдэг Эмгэнэх бичгийн ai-哀 гэдэг нь гашуудах, эмгэнэх, харамсах гэсэн утгатай бөгөөд ce-册 гэдэг нь дэвтэр, боть, ном гэсэн утгыг илэрхийлнэ. Энэ нь үүрэг зориулалтын хувьд зөвхөн хаан болон хааны хатан, угсаа залгамжлах хунтайж, хааны эх нас барсан тохиолдолд ордноос тусгайлан бэлдсэн гантиг дээр гашуудлын үг бичиж дагалдуулан оршуулдаг. Эмгэнэх бичиг дээр ихэвчлэн талийгаачийн тухай гашуудсан үг бичихээс гадна улс орны байдал, түүх зэргийг цухас дурддаг. Судлаачдын гаргасан тоо баримтаас харахад Тангийн үеийн 38 бунхнаас эмгэнэх бичиг илэрсний дотор хаанд 13, ханхүүд 8, хааны хатанд 13, хааны эхэд 3 тус тус зориулан хийсэн нь малтлагын явцад илэрсэн байна (Fan Yingfeng, Bai Genxing 2006: 251). Тухайлбал И Дэ хунтайжийн бунхнаас 11 ширхэг, Хуйжао хунтайжийн бунхнаас 127 ширхэг (Wang Yulong, Cheng Ruiping 2003: 51), Жиemin хунтайжийн бунхнаас 59 ширхэг (Shaanxi 2004: 143) гарсан зэргийг

энд жишээ болгон дурдаж болно. Үүнээс гадна нэг үе өөрийгөө хаанд өргөмжлөн Ан Лушаньтай хамтарч Тан улсыг эрхшээлдээ оруулан захирч явсан согд гаралтай жанжин Ши Симингийн бунхнаас гарсан байдаг (Ai Jinjing, Zhao Fusheng 1991: 30). Мөн ОХУ-ны Хакасын Абакана уулын Райковын суурингаас НТ 866 онд үед холбогдох хятад бичээстэй, цуулдсан хэлбэрийн чулуунууд илэрчээ (Тэцу Масумото 1996: 208). Дээрхээс үзэхэд эмгэнэх бичгийг эхэн үедээ зөвхөн хааны оршуулгад зориулан хийдэг байсан бол сүүл үедээ түүний хэрэглээ нь өргөсөж хааны гэр бүл болон язгууртан нарт мөн хийдэг бичгийн төрөл болохыг дээрх баримтаас төвөггүй мэдэж болно.

Бидний өгүүлэн буй Уйгурын Хар балгасаас олдсон ханз үсэгтэй, гантиг чулууд нь булш оршуулгаас бус хотын доторх барилга байгууламжаас бүгд илэрч олдсоныг зайлшгүй анхаарч үзэх ёстой. Иймээс эдгээр нь Эмгэнэх бичиг бус, харин Цол өргөмжлөх бичигтэй холбоотой бөгөөд гантиг чулууны хугархайнууд дээрх ханз үсгийн зурлага, үгийн утга зэргийг Тан улсын түүхэнд холбогдох тулгар сурвалжуудаас шүүж үзэхэд бичээст гарч буй олон тооны үг хаадын зарлигийг тэмдэглэн үлдээсэн “Тан улсын зарлигийн түүвэр”, “Тангийн бүрэн судар” нэртэй сурвалжуудын Уйгурын хаанд цол өргөмжилсөн бичигтэй нийлж байна. Тухайлбал, Тан улсын яруу найрагч Бай Жу И (白居易 772- 846) -гийн эмхэтгэн найруулсан “Уйгурын хаанд шинээр цол өргөмжлөх бичиг” болон “Уйгурын хаанд нэмж цол өргөмжлөх бичиг” гэсэн хоёр зарлиг бичгүүдийн эх дотор Хар балгасаас олдсон ханз үсэгтэй гантиг чулууны 17 ширхэг хугархай дээрх 43 тооны ханз утга үсэг гарч байна. Иймээс Орхоны Хар балгасаас олдсон эдгээр ханз үсэгтэй гантиг чулуудыг Хятадын Тан улсаас Уйгурын төрийн эрхийг авч хаан ширээнд заларсан явдалд зориулан, уйгур хааны эрх мэдлийг баталгаажуулан илгээсэн “цол өргөмжилсөн бичиг” хэмээн үзэх бүрэн үндэстэй юм.

Судлаачдын тогтоосноор Тан улсын бичгийн их хүмүүн Бай Жу И-гийн найруулан бичсэн, хөрш улс руу илгээсэн захидал, цол өргөмжлөх бичээс, зарлигийн бичиг нийт 12 тоонд хүрэх бөгөөд үүнээс Уйгурт хамаарах 3 бичгийг тэрбээр бичсэн аж (Fu Xinglin 2006: 258). Эдгээрийн дотроос түүний бичсэн, Чундэ хаанд зориулсан өргөмжлөх хоёр бичээсийн хэсгүүд Хар балгасаас олдлоод байна гэж үзэж болохоор болов.

Үүнээс гадна Хар балгасаас олдсон бичигтэй чулууд дотор хятад сурвалж дахь цол өргөмжлөх хоёр бичигт дурдагдаагүй, олон тооны үг бий. Эдгээрийг бид Уйгурын бусад хаадад зориулан бичсэн цол өргөмжлөх бичгийн хэсгүүд хэмээн таамагласан бөгөөд үүний учир шалтгааныг хойно дэлгэрэнгүй өгүүлнэ. Учир нь энэ төрлийн бичээсийг эзэн хаан зарлиг буулгаж тусгай яамнаас бичгийн түшмэдийг

томилж, нарийн дэг ёсны дагуу үйлддэг журамтай байсан агаад Хятадын нутгаас олдсон энэ төрлийн харьцангуй бүрэн бүтэн хадгалагдсан олдворуудаас үзэхэд чулуунууд нь бүгд нэг ижил хэмжээтэй, нэг тигээр бичигдсэн байдаг. Тиймээс бидний Хар балгасаас олсон 46 ширхэг гантиг чулууны хугархай хэсгүүд дээрх ханз үсгийн бичлэгийн тиг, үгийн утга, чулууны үндсэн хэмжээсүүд дээр тулгуурлан дөрвөн төрөлд хуваан үзэж болохоор байна. 1-р төрлийн бичээсийг Чундэ хаанд шинээр цол өргөмжилсөн бичиг, 2-р төрлийн бичээсийг Чундэ хаанд цол нэмж өргөмжилсөн бичиг, 3-р бичээсийг Жаоли хаанд цол өргөмжилсөн бичиг, 4-р төрлийн бичээсийг нэр нь тодорхойгүй хааны цол өргөмжилсөн бичиг хэмээн ангилав.

1-р төрлийн бичээс: Чундэ хаанд шинээр цол өргөмжилсөн бичиг (册新回鹘可汗文)

Чундэ хаан бол 821-824 онд төр барьсан, Уйгурын хаант улсын 11-р хаан бөгөөд Тэнгэрт хувь олсон баатар хүчит мэргэн дээд эрдэмт хаан хэмээх сүрлэг цолтой байжээ (Эрдэнэбат 2018: 159). Тэрээр өмнөх Бао И хааны бодлогыг үргэлжлүүлэн явуулж Чанань хот руу 2000 хүний бүрэлдэхүүнтэй элч илгээн улмаар Тайхэ гүнжтэй ураг барилдсан байдаг.

Энэ төрөлд хамаарах гантиг чулуун дээрх бичээсүүд нь Хар балгасын НВ-2 талбайн цитаделиас нийт 9 ширхэг олдсон байна. Барилгын нуранги дотроос гарсан хятад бичээстэй гантиг чулууд нь цайвар шаргал өнгөтэй, зарим нь ихэд шатаж түлэгдсэн бол худаг дотроос олдсон нь цагаан өнгөтэй, хадгалалт харьцангуй сайн байдаг. Үүнээс үзвэл, уг эдлэлийн уул өнгө нь цагаан байсны зэрэгцээ хонхойлгон сийлсэн үсгийг дээрээс нь алтаар бүрсэн байжээ. Ерөнхийдөө нарийхан урт цуудсан хэлбэртэй бөгөөд бүгд хугархай хэсгүүд тул уртын хэмжээг тодорхойлох боломжгүй. Дунджаар өргөн 2,8-2,9 см, зузаан 1-1,2 см хэмжээтэй. Эдгээр 9 ширхэг чулуун дээрх утга үсгүүдийг хятад сурвалжийн бүрэн эх дотор байрлах дарааллын дагуу тодорхойлж уншив.

1. 北之氣-bei zhi qi. Гол хэсэгт 之-zhi гэсэн ханз үсэг тодорхой мэдэгдэнэ. Түүний дээр буй ханзны босоо (shu) болон ташуу (shuti) зурлагаас үзвэл 北-bei буюу умард гэсэн утгатай үг байх боломжтой бол хамгийн сүүлийн гурав дахь ханзны дээд талын зурлагаас харвал 氣-qi буюу цаг уур гэсэн үгс байна. Эцэст нь эдгээрийг нийлүүлэн уншвал 北之氣-bei zhi qi буюу “Умардын цаг уур” гэсэн утга гарна. Хугархайн урт 6 см, өргөн 2,8 см, зузаан 1 см хэмжээтэй (Зураг 2-1).

2. 較雄-jiao xiong. Чулууны нүүрэн хэсэгт 較雄-jiao xiong гэсэн хоёр ширхэг ханз үсэгтэй. 1-р ханзны дээд талын хөндлөн (heng), ташуу дусал (xiedian) зурлагууд нь баларсан ч гэсэн жиао гэсэн ханз болох

нь бусад зурлагуудаас тодорхой мэдэгдэнэ. Эдгээрийг орчуулбал 較-jiao гэдэг нь адилтгах, харьцуулах, 雄-xiong эрэлхэг, хүчирхэг гэсэн утгатай. Эдгээрийг нийлүүлж уншвал хүч ухааныг адилтгах гэсэн утга гарна. Хугархайн урт 14,5 см, өргөн 2,8 см, зузаан 1,1 см хэмжээтэй (Зураг 2-2).

3. 不德-bu de. 1-р үсэг нь 不-bu буюу эс, үгүй, биш гэсэн үгүйсгэсэн утгатай ханз үсэг тодорхой мэдэгдэх бол түүний доод талд буй үсгийн эхний хоёр сацлага (piedian) болон ташуу, босоо зурлагуудаас үзвэл 德-de гэсэн ухаан бодол, ёс суртахуун гэсэн ханз байх боломжтой. Эдгээрийг нийлүүлж уншвал 不德-bu de буюу “ухаан бодолгүй” гэсэн утга гарна. Хугархайн урт 4,3 см, өргөн 2,9 см, зузаан 1 см хэмжээтэй (Зураг 2-3).

4. [咨]尔-zi er. 4-р чулуун дээр буй хоёр үсгийн сүүлийн 尔-er гэсэн ханз тод мэдэгдэх ба өмнө талын 口-kou үсгийн тэмдэгтээс үзвэл 咨-zi гэсэн ханз үсэг байх боломжтой. Учир нь Чундэ хааны цол өргөмжлөх бичгийн эхэд энэхүү хоёр ханзыг түүний цолны өмнө бичсэн байна. [咨]尔-zi er хэмээх хоёр үг нь ихэвчлэн өгүүлбэрийн эхэнд бичигддэг бөгөөд захирах, хүсэх утга бүхий аялга үг юм. Харин бичээсийн эхэд 尔-er гэсэн үгийг 爾 хэмээх ижил дуудлагатай, өөр бичлэгтэй ханзаар тэмдэглэжээ. Энэ магадгүй зарлигийн бичгийн хожим хуулж бичихдээ өөр ханзаар тэмдэглэсэн байхыг үгүйсгэхгүй. Хугархайн урт 4,8 см, өргөн 2,8 см, зузаан 1,1 см хэмжээтэй. Чулуун дээр бичсэн ханз үсгийг дээрээс нь алтадсан байна (Зураг 2-4).

5. 君登-jun deng гэсэн хоёр ханз үсэгтэй. 2-р ханз үсгийн төгсгөлийн хөндлөн зураас хэсгээрээ хугарчээ. 1-р ханз болох 君-jun гэсэн үгийг Түрэг хэлний kün буюу нар гэсэн үгийг хятад сурвалжид 君-jun эсвэл 军-jun гэсэн ижил дуудлагатай ханз үсгүүдээр тэмдэглэдэг уламжлалтай бөгөөд ихэвчлэн хааны цолонд гардаг. Харин үндсэн утга нь эзэн, эрхэм гэсэн үг бөгөөд түрэг хэлний үгийг галиглаж бичсэн хэсэгт гарч буй тул бид үүнийг нар гэсэн хааны цол хэмээн үзсэн болно. 2-р ханз нь 登-deng буюу тэнгэр хэмээх үгийг тэмдэглэдэг 登里-dengli гэсэн ханзны эхний үг байна. 登里-dengli буюу tānggrī- тэнгэр гэсэн үг Түрэг, Уйгурын хаадын бүх цолонд дурдагддаг билээ. Чундэ хааны цолонд гарч буй энэхүү 君登-jun deng гэсэн үг нь нарны тэнгэр бурхан гэсэн утга илэрхийлнэ. Хугархайн урт 6 см, өргөн 2,8 см, зузаан 1 см хэмжээтэй (Зураг 2-5).

6. 使[朝] - shi [chao]. Чулууны нүүрэн хэсэгт 使-shi буюу илгээх, явуулах, элч гэсэн утгатай ханз үсэг мэдэгдэнэ. Түүний доод талд мэдэгдэж буй цаози үсгийн тэмдэгтийн дээд хэсгээс үзэхэд [朝-chao] хэмээх улс гүрэн эсвэл бараалхах гэсэн үг байх боломжтой. Эдгээрийг нийлүүлж уншвал улсад илгээх гэсэн утга гарах боловч Чундэ хааны

цол өргөмжлөх бичээсийн эхтэй тулгаж үзвэл эхний 使-shi нь элч, дараагийн 朝-*chao* гэдэг нь 朝議 гэсэн албан тушаалын нэрийн хэсэг байна. Өөрөөр хэлбэл, тус өргөмжлөх бичгийг авч Уйгурын Чундэ хаан луу явсан түшмэлийн цол хэргэмийг бичжээ. Хугархайн урт 5 см, өргөн 2,8 см, зузаан 1,1 см хэмжээтэй (Зураг 2-6).

7. 兼少-jian shao. 1-р ханзны дээд хэсгийн зурлагууд хугарч арилсан боловч 兼-jian буюу хамрах хамтад нь гэсэн утгаар уншигдах боломжтой. 2-р ханз 少-shao буюу цөөн, ховор, бага зэрэг утгатай боловч энд 少府監 —шаофү яам гэсэн утгаар гарч байна. Хугархайн урт 5 см, өргөн 2,9 см, зузаан 1 см хэмжээтэй (Зураг 2-7).

8. [備]物-[bei] wu. 1-р ханзны дээд хэсгийн зурлагууд арилсан боловч 備-bei буюу бэлтгэх, эзэх гэсэн утгатай үг байна. 2-р ханз нь 物-wu буюу эд зүйл, бараа гэсэн утгатай. Энэхүү хоёр ханзыг нийлүүлж уншвал [備]物-[bei] wu буюу эд зүйл бэлтгэх гэсэн утга гарч байна. Ханз үсгүүдийг алтадсан. Хугархайн урт 3,2 см, өргөн 3 см, зузаан 1,2 см хэмжээтэй (Зураг 2-8).

9. 於戲善必-wu hu shan bi гэсэн дөрвөн ханз үсгийг сийлсэн. Эдгээрээс эхний хоёр ханз болох 於 戲-wu hu гэдэг нь магтан сайшааж буйгаа илтгэсэн аялга үг бол дараагийн 善-shan буюу энэрэнгүй, буянтай, 必-bi буюу зайлшгүй гэсэн утгатай. Хугархайн урт 12,8 см, өргөн 2,8 см, зузаан 1 см, нэвт сүвлэх нүхний голч 0,4 см хэмжээтэй. Чулууны доод хэсгийн хажуугаас сүвлэх нэвт нүхтэй (Зураг 2-9).

Дээр дурдсан Чундэ хаанд цол өргөмжилсөн бичиг хэмээн үзсэн 1-р төрөлд хамаарах эдгээр 9 ширхэг чулууны хугархай дээрх 21 ширхэг ханз үсгүүд “Тан улсын зарлигийн түүвэр-唐大詔令集” сурвалжийн 129-р дэвтэр болон “Тангийн бүрэн судар” сурвалжийн 666-р дэвтэрт буй “Уйгурын хаанд шинээр цол өргөмжлөх бичиг” хэмээх эхэд дараах байдлаар гарч байна. Бид Уйгурын нийслэл Ордубалык буюу Хар балгасаас олдсон олдвор дээрх үсгийг уг эх дотор нь тодруулан тэмдэглэв.

《全唐文》卷666《冊新迴鶻可汗文》 維長慶元年歲次辛丑四月庚寅朔二十一日庚戌皇帝若曰唐有天下垂二百載列聖垂拱八荒即

敘舟車之所及日月之所照威綏仁董罔不嚮化惟北之氣積厚而靈靈發象生生為豪傑義信武烈代為名 王南西東方亦有君長較雄鬪智莫之與京國朝已來宴漬風澤或効功伐或申婚媾同和協比以託於今

朕不德祇嗣大統推義布信以初為常矧乎柔遠申恩睦隣展禮茲惟舊典垂自祖宗虔奉恭行安敢失墜咨 爾[尔]九姓迴鶻君登里羅羽錄沒密施句主錄毗伽可汗地生奇特天賜勇智英姿所莅雄略所加諸戎雜虜 愛畏柔服風靡山立清寧一方宜人有土受天百祿時推代嗣實來告予曰予一人實隣冊命是用遣使朝議大夫檢校左散騎常侍兼少府監御史大夫雲騎尉賜紫金魚袋裴通

副使朝議大夫守少府少監兼御史中

丞襲魏國公食邑三千戶賜紫金魚袋賈麟離珍/切等持節備物冊為登里羅羽錄沒密施句主錄毗伽可汗。

於戲善必有鄰德無不答此崇恩禮則彼竭信誠克保大義永藩中夏昭昭天地實聞斯言。

Тангийн бүрэн судар, 666-р дэвтэр: Уйгурын хааны шинээр цол өргөмжлөх бичиг

Чанчингийн тэргүүн оны (821) цагаагчин үхэр жилийн цагаан бар дөрөвдүгээр сарын шинийн хорин нэгний цагаан нохой өдөр хаан өгүүлрүүн: Тан улс тэнгэрийн дор хоёр зуун жил тогтноход, дээдэс хүч заралгүйгээр атаршсан газруудад хэргэм зэрэг, соёрхлыг хүртээж, тэрэг хөсөг болон завь хүрч чадах, наран сарны гэрэл гийгүүлэх газарт сүр хүч энэрэл журмыг тогтоон төвхнүүлсэн болой. Гэвч умардын цаг агаар нь хүч ухааныг хураан цуглуулсан, тэрхүү хүч ухаан нь баатрыг төрүүлж өгдөг, төрөхдөө шударга үнэнч, эрэлхэг зоригтой тул эзэн хаан болгодог. Өмнөд, баруун, зүүн зүгийн эзэн ноёд нь болбоос умардын ноёдтой хүч ухаанаар нь адилтгавч дүйхгүй. Улс байгуулагдсан цагаас эхлэн энэрэл хайранд умбуулж, дайн тулаан төдийгүй ураг барилдах үйл хэрэгт хоорондоо харилцан зохицолдож өнөөдрийг хүрчээ. Өнөөдөр эзэн хаан би ухаан бодолгүйгээр хаадын угийн бичигт залгамжлуулан үлдээж, шударга үнэнийг түгээн дэлгэрүүлж хуучин хэвд нь оруулаа. Мөн тэгээд ч ач хайрыг үзүүлэх нь мөнхийн энэрэл байдаг тул өвөг дээдсээс уламжилж ирсэн хуучны ёсыг даган, хичээнгүйлэн мөрдөж [бас] хэрхэн зүрхлэн алдах билээ. Чи (хаан) бол Есөн овгийн Уйгурын нарны(эзэн) тэнгэрт болгоогдсон мэргэн цэцэн хаан, онцгой газарт төрсөн, тэнгэрт ивээгдсэн зоригтой ухаалаг, [аливааг] төвхнүүлэх баатарлаг төрхтэй, нэмээд гарамгай арга ухаантай, бүх бүдүүлэг (өмнөдийн ман) аймгууд захирагдахаас айж, гарди дагуулан уул босгож өөрийн газрыг номхотгосон тул энэ хүний нутаг нь тохирч дээд тэнгэрээс зуу дахин ерөөл хүртсэн тухай, үе үеийн төлөөлөл ирж зарлав. Энэ хүнийг цол өргөмжлүүлэхээр төрийн хэргийг шүүх дайфү, шалгах түшмэл зүүний санчи чанши, жианшао фүжиан, юүши дайфү, юнчи вэй, алтан загасан чимэглэлт пэйтун, төрийн хэргийг шүүх дэд дайфү, шоу шаофү шаожиан, жиан юүши жунчэн, сивэй улсын гүн, хоол хүнстэй гурван мянган өрх, алтан загасан чимэглэлт жиалин зэрэг түшмэлийг илгээж, ёслолд хэрэглэгдэх эд зүйлсийг бэлтгэн, тэнгэрт болгоогдсон мэргэн цэцэн хаан хэмээн өргөмжлөв. Аяа! Цайлган хөрш минь, эрхэм зан чанарт чинь хариу илгээж чадахгүй. Эрхэм дээд соёрхлыг тань хүндэтгэн хүлээн авсан тул заавал үнэнчээр дагаарай, шударга ёсоо хадгалж үргэлж Тан улсын хараат байгаарай. Энэ амлалт үг тэнгэр, газрын сонорт хүрэг!

2-р төрлийн бичиг. Чундэ хаанд цол нэмж өргөмжилсөн бичиг (册回鹘可汗加号文)

Чундэ хааныг шинээр хаанд өргөмжилсний дараа удалгүй Уйгураас Тан улстай ураг барилдах хүсэлтэй элч төлөөлөгчид 821 оны 5-р сард Чанань хот иржээ. Энэ үед Тан улсын хаан Сианзун өөрийн 10-р охин Тайхэ гүнжтэй ураг барилдахыг зөвшөөрч элч төлөөлөгчдийн хамт илгээхдээ Чундэ хааныг дахин цол өргөмжилж, бичээсийг нь гүнжийн хамт илгээсэн нь 822 оны 2-р сарын эхээр Ордубалык буюу Хар балгасанд хүрэлцэн ирсэн байх боломжтой (Мөнхтулга 2017: 201).

Хар балгасаас олдсон энэ төрөлд хамаарах олдворууд нь 8 ширхэг чулуун дээр 19 тооны ханз үсэг сийлжээ. Эдгээрийг бичээсийн эхэд гарч буй дарааллын дагуу доорх байдлаар тодорхойлов.

1. 若曰-guo yue. Чулууны гол хэсэгт 曰-yue хэмээх ханз тодорхой мэдэгдэх ба түүний дээд талд буй ханзны хэсгүүдээс үзвэл 若-guo гэсэн ханз байна. Эдгээрийг нийлүүлэн уншвал 若曰-guo yue буюу өгүүлэх, өгүүлрүүн гэсэн утга гарна. Хугархайн урт 5,2 см, өргөн 2,8 см, зузаан 1,1 см (Зураг 3-1).

2. 北[方]-bei fang. Хугархайн дээд хэсэгт 北-bei буюу умард, хойд гэсэн утгатай үг тодорхой мэдэгдэнэ. Түүний доод талд буй үсэг баларсан боловч дусал (dian) болон хөндлөн зураасны (heng) хэсгүүдээс үзвэл [方-fang] буюу зүг чиг, нутаг орон гэсэн утгатай үг байна. Эдгээрийг нийлүүлэн уншвал умард зүгийн/нутгийн гэсэн утга гарна. Хугархайн урт 4,2 см, өргөн 2,8 см, зузаан 1 см (Зураг 3-2).

3. 沒密[施]-mo mi shi. Чулууны гол хэсэгт 沒密-mo mi гэсэн хоёр ханз тодорхой мэдэгдэх бөгөөд түүний доод талд буй ханз баларсан боловч хадгалагдаж үлдсэн дээд хэсгийн зурлагуудаас үзэхэд 施-shi гэсэн үг байна. Эдгээр 沒密[施]-mo mi shi гэсэн гурван ханз нь bolmiš гэсэн түрэг үгийг галиглан тэмдэглэсэн үг бөгөөд ихэвчлэн Түрэг, Уйгурын хаадын цолонд гардаг соёрхогдсон, болгоогдсон гэсэн утгыг илэрхийлнэ. Энэ үгтэй ижил утга бүхий үгийг түрэг судлаачид дараах байдлаар уншиж тайлжээ. Тухайлбал, академич Л.Болд Күлтегиний бичээсэнд гарч буй “bolmiš” хэмээх үгийг “өршөөгдсөн / түүний заяагаар” (Болд 2011: 59), доктор Б.Аззаяа Моюнчурын гэрэлт хөшөөний бичээст буй “bolmiš” хэмээхийг “болгоогдсон” (Аззаяа 2013: 56) гэж уншжээ. Хугархайн урт 5,7 см, өргөн 2,8 см, зузаан 1 см (Зураг 3-3).

4. 於天下氣[無]-yu tian xia qi wu. Хар балгасаас одоогоор олдоод буй гантиг чулууны хугархайн дотроос хамгийн олон буюу 5 ширхэг ханз үсэгтэй эдлэл бөгөөд Ордон хотын НВ-2 талбайн худаг дотроос олджээ. Цуулдасны дээд хэсгийн хажуугаас нэвт цоолсон хэлхэж зүүх зориулалттай нүхтэйгээс үзвэл

хамгийн дээд хэсэг бололтой. Нүүрэн хэсэгт дээрээс доош чиглэлд нийт 於天下氣無-yu tian xia qi гэсэн 4 ханз үсэг тодорхой мэдэгдэх ба түүний доод талд буй үсгийн дээд хэсгийн зурлагуудаас үзэхэд 無-wu гэсэн үсэг байна. Эдгээрийг нийлүүлж уншвал тэнгэрийн дор, цог золбоо үл... гэсэн утга гарна. Хугархайн урт 16,1 см, өргөн 2,8 см, зузаан 1 см, хэлхэх нүхний голч 0,5 см (Зураг 3-4).

5. 仍舊[姻]-reng jiu yin. Чулууны нүүрэн талд нийт 3 ширхэг ханз үсэг дүрсэлсэн байна. Үүнээс 仍 舊-reng jiu буюу урьдын ёсоор гэсэн утгатай үг тодорхой мэдэгдэнэ. Харин гурав дахь үсэг голоор хугарсан боловч ниүзипан (女字旁)хэмээх хажуугийн тэмдэгтээс үзвэл 姻-yin буюу ураглах, хуримлах гэсэн утгатай үг байх боломжтой. Эдгээр үсгүүдийг нийлүүлж уншвал “... урьдын ёсоор ураг барилдах” гэсэн утга гарна. Хугархайн урт 7,1 см, өргөн 2,8 см, зузаан 1 см (Зураг 3-5).

6. [柔]遠為-rou yuan wei. Чулууны нүүрэн талд 遠為-yuan wei гэсэн хоёр ханз үсэг тодорхой мэдэгдэнэ. Эдгээр үсгийн өмнө талд буй үсгийн зөвхөн доод хэсгийн зурлагуудад тулгуурлан үзвэл 柔 -rou гэсэн ханз байна. Эдгээрийг нийлүүлж уншвал “зөөлнөөр хандах” гэсэн утга гарна. Хугархайн урт 7,4 см, өргөн 2,8 см, зузаан 1 см (Зураг 3-6).

7. [於] - wu hu. Хоёр ширхэг ханз үсэг байгаа боловч 1-р ханз үсэг баларч мэдэгдэхгүй болсон. Гэсэн хэдий ч хажуугийн дусал зурлагуудаас үзэхэд 於 -wu hu буюу магтан сайшаах утгыг илтгэсэн аялга үг юм. Үүнтэй ижил утгатай үг 1-р бичээсийн 9 дугаартай чулуун дээр гарч байна. Чундэ хааны шинээр цол өргөмжлөх бичээст гарсан -hu хэмээх ханз үсэг болон энд гарч буй ханз үсэг хоёр утгын хувьд ижил боловч зарим нэг зурлагыг өөр өөрөөр бичсэн нь сонирхол татна. 1 болон 2-р бичээсийг Бай Жү И зохиосон тухай сурвалжид тодорхой тэмдэглэсэн ба мэдээж гантиг чулуун дээр сийлэхдээ хааны зарлиг учир чулуу урлаач өгсөн эхийн дагуу алдаагүй бичсэн нь ойлгомжтой. Тэгэхээр зохиогч тус хоёр ханз үсгийг өөр өөр зурлагаар бичсэн гэсэн таамаг дэвшүүлж болох хэдий ч нэг эхийг нь түүнээс өөр хүн бичсэн байхыг үгүйсгэх аргагүй юм. Хугархайн урт 4 см, өргөн 2,8 см, зузаан 1,1 см (Зураг 3-7).

8. 始終-shi zhong. Энэ нь хоёр ханз утга үсэг нь хэдий өөр өөр газраас илэрсэн боловч хугарсан эвээрээ хоорондоо нийлнэ. Нийлүүлэн уншвал 始終-shi zhong буюу эхлэл төгсгөл гэсэн утга гарна. Хугархайн урт 7,9 см, өргөн 2,9 см, зузаан 1 см (Зураг 3-8).

Хар балгасаас олдсон Чундэ хаанд цол нэмж өргөмжилсөн бичиг буюу 2-р төрөлд хамаарах 8 ширхэг чулууны хугархай дээрх 19 ширхэг ханз үсгүүдийг “Уйгурын хаанд цол нэмж өргөмжлөх бичиг” хэмээх эх дотор нь тодруулан тэмдэглэв.

《全唐文》卷666《册回鹘可汗加號文》

維長慶元年歲次辛丑某月朔某日，皇帝若曰：北方之強，代有君長，作殿 朔，實於皇唐。 粵我祖宗，錫乃婚媾，五聖六紀，二邦一家，此無北伐之師，彼無南牧之馬，兵匪鋒刃，使長子 孫，叶德保和，以至今日。咨爾回鹘君登里羅羽錄沒密施句主錄毗伽可汗，義智忠肅，武力勇 健，天之所授，時而後生，故東漸海夷，西亘山狄，惠寧威制，鱗帖草偃，聲有聞於天下，氣無 敵於荒外。而能事大圖遠，納忠進賢，請仍舊姻，誓嗣前好。朕惟睦鄰是務，柔遠為心，既降和 親之命，遂申納配之禮。禮物大備寵章有加喜動陰山光增 宿夫以回鹘雄桀如彼慶榮若此雖自貴 曰天驕子未稱其盛雖自號曰天可汗未稱其美宜賜加號以大誇將來今遣使某官副使某官某等持節加 信義勇智雄重貴壽天親可汗。於戲！釐降展親，大德也；進册加號，大名也。宜思大德，稱大名，懋哉始終，欽若唐之休命。

Тангийн бүрэн судар, 666-р дэвтэр: Уйгурын хаанд цол нэмж өргөмжилсөн бичиг

Чанчингийн анхдугаар оны (821) цагаагчин үхэр жилийн ивээлт сар өдөр, Хаан өгүүллүүн: хүчирхэгжсн мандсан умардад үеийн үед хаад төрөн гарч, орд өргөөгөө байгуулан, Тан улстай анд нөхөд болжээ. Миний өвөг дээдэс ураг барилдан холбоо тогтоож, таван богд (хаан) зургаан үеийн дараагаас хоёр улс нэгэн гэр болов. Бидэнд умардыг дайлаар мордох цэргийн хүч үгүй, та нарт өмнөд нутагт адгуулсан цэргийн морьд үгүй. Цэргийн зэр зэвсэг, хутгаа үр хойчдоо үлдээн, бид ач гавьяагаа хадгалж энх тайвнаар өнөөдрийг хүрчээ. Чи бол Есөн овгийн Уйгурын нарны тэнгэрт ивээгдсэн мэргэн цэцэн Билгэ хаан. Шударга, цэцэн ухаан, үнэнч, хянамгай, чийрэг бүхий хүч сэтгэлтэй бол дээд тэнгэрт зөвшөөрөгдөж хожим өөрийгөө төрөн гаргана. Тиймээс зүүнээс далайн хязгаар хүртэлх И нар, баруунаас уулсын чанад дахь Ди нарын газар нутгийг эрхшээж, ивээл болон ач тусыг ноёлж, ард түмэн нь хайрсан дэлбээ, найгах өвс адил дуулгартай даган, нэр цуу нь тэнгэрийн доорх бүхэнд сонсогдож ээрэм талд хүртэл дайсан үгүй болой.

Гэвч их улсад тахил өргөж үнэнч шударгаар төлөх, урьдын ёсоор ураг барилдахыг хүсэмжлэхэд өвөг дээдсийнхээ өмнө тангараглав. Эзэн хаан би хөршийн харилцааг чухалчлан үзэж, үргэлж зөвлөн сэтгэлээр хандан, хааны угсааны гэр бүлийн зарлигт оруулж ёслолд шаардагдах зүйлд бэлдэгтүн. Бэлгийг сайтар бэлдээд онцгойлон энхрийл, Монь уул (Иншан) доргих, ...од хувирч гэрэлтэхийг [харах] дуртай. Уйгур улс ийм гарамгай, ийм алдартай боловч тэнгэрийн хөвүүн хэмээн хүндэтгэн дуудах нь хөгжсн бадрахад нийцэхгүй, өөрөөр тэнгэрийн хаан гэвэл бас сайн сайханд мөн нийцэхгүй. Тиймээс тэдний ирээдүйг ингэж магтан дуудах болно. Өнөөдөр элч төлөөлөгчдөөр ёслолд хэрэглэгдэх эд зүйлсийг

бэлтгэн журамт мэргэн цэцэн, баатарлаг тэнгэрийн хаан хэмээн цол өргөмжлөв. Аяа! мөнхийн ураг садан болох нь их гавьяа болой. Цол нэмж өргөмжлөх нь их нэр хүнд болой. Энэхүү их гавьяа, нэр хүндийг Тан улс ямагт тэмдэглэн үлдээнэ.

2-р бичээсийн агуулгаас харахад, Чундэ хааны сүр хүч, алдар гавьяаг магтан дуулж улмаар нэг жилийн дотор дахин “журамт мэргэн цэцэн, баатарлаг тэнгэрийн хаан” хэмээн цол өргөмжлөхийн хамт, өмнөх түүхэн уламжлалаа санагалзаж ураг барилдан хоёр улс нэг гэр бүл болов хэмээн онцлон тэмдэглэсэн болохыг дээрх эхээс төвөггүй мэдэж болно. Харин энд нэг жилийн дотор яагаад дахин цол өргөмжлөх болов гэсэн асуулт урган гарах нь тодорхой бөгөөд бид үүнийг Тайхэ гүнжтэй Уйгурын хаан ураг барилдсан явдалтай холбон дор дэлгэрэнгүй тайлбарлана. Тиймээс юун түрүүнд Тан улсаас Уйгурт ирсэн гүнж нар болон ураг барилдаж байсан түүхийн талаар эхэлж тодруулах нь зүйтэй. Анх Хүннү болон Хан улсын үеэс хоорондоо ураг барилдаж эхэлсэн энэхүү энх ургийн гэрээ нь дараа дараагийн төрт улсуудад уламжлагджээ. Харин Тан улсын үед хил залгаа улсууд болон томоохон овог аймгуудтай нийт 28 удаа ураг барилдсаны дотор Түрэгүүдтэй 6 удаа, Уйгуруудтай 8 удаа энх ураг барилдсан байна (Gong Yin 2000: 106).

Анх 756 онд Уйгурын Билгэ гүнж, Дунхуаны ноён Ли Чэнцайтай энх ураг барилдсан бол 758 оноос эхлэн Тан улсаас хааны болон өндөр дээд язгууртан угсааны долоон гүнж ирж Уйгурын хаадын хатан болжээ. Үүнийг задлан үзвэл 758 онд Уйгурын Пэйло хаантай Тан улсын Сүзун хааны бага охин Нингуо гүнж, 759 онд Моюнчур хаантай Пүгү Хуанэнгийн охин Гуанчин гүнж болон Рунг вангийн охин бага Нингуо гүнж, 769 онд Бөгү хаантай Пүгү (Бух) аймгийн Хуанэнгийн охин Чунхуй гүнж, 788 онд Тун Бага хаантай Дээун хааны 8-р охин Сиан Ан гүнж, 789 онд Пангуань Дэлэ хаантай Пүгү Хуанэнгийн ач охин Еэ гүнж, 821 онд Чундэ хаантай Тайхэ гүнж тус тус ураг барилджээ. Үүнээс үзвэл, бичээст урьдын ёсоор ураг барилдахыг хүсэмжилсэн хэмээн өгүүлсэн нь Тайхэ гүнжээс өмнө ирсэн бусад гүнж нарын талаар онцлон хэлсэн бололтой.

Тан улстай ураг барилдах хэрэг зарим тохиолдолд төдийлөн Уйгуруудын хүссэнээр болоогүй нь мэдэгддэг. Энэ нь нэг талаар Тан улсын дотоод нөхцөл байдалтай шууд холбоотой бөгөөд ураг барилдсанаар гүнжийн инжинд ирэх бэлэг сэлт, ёслолын зардлаас гадна бусад худалдаа наймааны томоохон хэлэлцээрүүд үргэлжлэн хийгдэх шаардлагатай болдог байжээ. Нэгэн жишээ дурдахад, Тан улсын Дээун хааны 8-р охин Сиан Ан гүнж 808 онд Уйгурт таалал төгссөний дараа Бао И хаан 808, 813, 817 онуудад ураг барилдахаар нийт 3 удаа элч илгээсэн боловч Сианзун хаан зөвшөөрөөгүй байна. Тухайлбал,

817 онд Бао И хаан ураг барилдуулахаар Манихейн шашны 8 хуврагийг элч болгон Чан Ань руу илгээжээ. Сианзун хаан ураг барилдахад хэрэглэх ёслолын зардлыг тооцон гаргахыг зарлиг болгоход нийт таван сая орчим хэлхээ зоос шаардлагатай хэмээжээ (Cun Mingde 2005: 339-340). Тухайн үед Тан улсын хязгаарын цэргийг захирах газраас дайнд бэлтгэж байсан тул ураг барилдахад шаардагдах дээрх зардлыг гаргах боломжгүй хэмээн шалтгааж, Уйгурын хаанд тусгай элч илгээн хэрэг явдлыг тайлбарлан, уучлалт гуйсан байдаг. Улмаар 821 онд Тан улсын Сианзун хаан нас барж түүний оронд Музун хаан сууснаар ураг барилдах ажил нааштай шийдэгдэх боломж гарч иржээ.

Энэ үед Уйгурт хатан болж ирсэн гүнж бол Сианзун хааны 10-р охин Тайхэ бөгөөд гүнжийн талаар “Хуучин Тан улсын судар”-ын Уйгурын шастирт доорх байдлаар тэмдэглэн үлдээжээ.

“五月，回鹘宰相、都督、公主、摩尼等五百七十三人入朝迎公主，于鸿胪寺安置。敕：“太 和公主出降回鹘为可敦，.... 以左金吾卫大将军胡证检校户部尚书，持节充送公主入回鹘及册可汗使”

“5-р сард (821 он), Уйгурын тэргүүлэгч сайд, дүдү, гүнж, манихейн хувраг зэрэг таван зуун далан гурван хүн гүнжийг угтан авч, төрд бараалхахаар ирсэнийг Хунлүси-д байршуулав. Зарлигт: Тайхэ гүнжийг Уйгурын кедун (хатан) болгов, зүүний Жинвүвэйг хамгаалах их жанжин Хүжэньг хубу-гийн шалган байцаах түшмэл болгож, залаат туг барцулан Уйгурт гүнж болон хаан өргөмжлөх бичээсийг хүргүүлэв” хэмээн тэмдэглэжээ.

Дээрх мэдээнээс үзэхэд гүнжийг угтан авахаар ирсэн элч нар хааныг нэмж цол өргөмжилсөн бичгийг хамт авч явсан бололтой. Гэвч 6-р сард, Тан улс Уйгуртай ураг барилдах болсныг Тубо нар мэдэж саад хийхээр одоогийн Ганьсу мужийн нутагт байх Цинсай боомт руу халдан довтлоход Янжоу-гийн түшмэл Ли Вэньюэ цэрэг гарган тэднийг эсэргүүцжээ. Үүнийг мэдсэн Уйгурууд Тайхэ гүнжийг нутагтаа саадгүй авчрахын тулд Бэйтин болон Аньси-гээс тус бүр нэг түмэн морьт цэрэг гаргаж Тубо руу довтолсон зэргээс үзэхэд тэд ихэд анхаарал хандуулж байсан нь харагддаг. Энэ мэтчилэн багагүй саад бэрхшээл гарсны эцэст 821 оны 7-р сард Тайхэ гүнж Чан Ань хотоос гарчээ. Гүнжийг авч ирсэн цувааны тэргүүн хэсэг Ордубалык буюу Хар балгасанд 822 оны 2-р сарын эхээр ирсэн бололтой (Мөнхтулга 2017: 201).

Тайхэ гүнж Уйгурт ирсэн зам харилцаа хийгээд Чундэ хааны хатан болсон тухай хуримын ёслолын сонирхолтой мэдээг “Хуучин Тангийн судар”-г тэмдэглэн үлдээжээ.

“可汗先升楼东向坐，设氍毹于楼下以居公主，使群胡主教公主以胡法。公主始解唐服而衣胡服，以一姬侍，出楼前西向拜。可汗坐而视，公主再俯

拜訖，复入氍毹中，解前所服而披可敦

服，通裾大襦，皆茜色，金饰冠如角，前指后出楼，俯拜可汗如初礼”

“Хаан (Чундэ) эхлээд ордонд заларч дорно зүгт хандан сууж, ордны доод талд гүнжид (Тайхэ) зориулан эсгий гэр барьж суулган, ху (уйгурын) олон элч гүнжид ху-гийн ёс заав. Гүнж эхлээд Тангийн хувцсаа тайлж, ху-гийн хувцас өмсөн, нэгэн настай асрагчаар [дагуулан] ордны өмнө баруун тийш хандуулан мөргөв. Хаан суудлаасаа харж, гүнж дахин сөгдөн мөргөв, дахин эсгий гэрт орж, урьд нь өмссөн хувцсаа тайлж, кэдуны (хатан) хувцас өмсөв. Задгай энгэртэй том хүрэм бөгөөд бүгд улаан өнгөтэй. Алтаар чимэглэсэн титэм нь эвэр шиг ба эхэлж заалган ордны хойд талаар гарч хаанд сөгдөн мөргөж эхний ёслол хийв” хэмээн тэмдэглэснээс бид тухайн үеийн хаад язгууртны хуримын ёслолын дэг жаягийн талаар зарим ойлголтыг авч болохын зэрэгцээ бүр уг үйл явдал Хар балгасын Ордон хотын дотор болсон гэдэг нь тодорхой юм.

Харин Чундэ хаан насан эцэслэсний дараа Кедун Тайхэ Уйгурын заншил ёсоор 825-832 онд Жаоли хааны хатан, 833-839 онд Жансинь хааны хатан, 839-840 онд Хэса (闐駁特勒) тэгиний хатнаар тус тус өргөмжлөгджээ. Өөрөөр хэлбэл, Тайхэ гүнж Уйгурт нийт 21 жил суухдаа 4 хааны хатан болсон бөгөөд улс доройтон мөхсөний дараа 842 онд арга буюу Чан Ань хот руугаа буцжээ. Уйгуруудын гэрлэх заншилд нөхрийн талын ах дүүтэй гэрлэх буюу асрахуйн ёс (levirate), эхнэрийн эгч, дүүтэй гэрлэх ёс (sororate), нэг нөхөр олон эхнэр авах (polygyny) ёс (Lin sixian 2012: 300) язгууртнуудын дунд түгээмэл байжээ. Урьд нь бага Нингуо гүнж 759-791 оны хооронд Моюнчур хаан болон түүний хүү Бөгү хаантай, Сиан ан гүнж 788-808 оны хооронд Тун Бага хаан болон түүний хүү Пангуань дэлэ хаан, Ачуо Фэнчэн хаан, Кутлуг хаантай тус тус ураг барилдаж байсан зэргээс харахад асрахуйн ёсны уламжлал Уйгурын дунд бусад нүүдэлчдийн адил хүчтэй байсны илрэл хэмээн үзэж болох юм. Хожмын монголчуудын заншилд, эр нөхөр нь үгүй болсны хойно бэлбэсэн хоцорсон эхнэрийг төрхөмд нь буцаадаггүй, харин талийгаач нөхрийн нь ураг төрлийнхөн түүнийг овогтоо үлдээж, тэдний хэн нэгэн нь түүнтэй гэрлэж, нас барсан садан төрлийнхөө гэргий, хүүхдийг нийт овгийн хамгаалалтад авдаг ёс байсныг асрахуйн ёс хэмээн нэрлэдэг (Эрдэнэбат 1997: 35) билээ.

3-р бичээс. Жаоли хаанд цол өргөмжилсөн бичиг

Талийгаач Чундэ хааны дүү Хэса (Хасар) тэгин нь 824 онд ахыгаа залгамжлан хаан ширээнд суусны дараа 825 онд Тан улсын Жинзун хаан цол өргөмжилсөн бичиг илгээжээ. Энэ тухай сурвалжийн мэдээнд “Тан

улсын хаан Чанчингийн (长庆) гийн 4-р онд (824) Уйгурын Чундэ (宗德) хаан нас барж, 120 түүний дүү Хэса Тэгин (曷萨特勤) хаан суув. Тан улсын Жинзун хааны Баолигийн анхдугаар оны (825) хавар, 3-р сард Ай Дэнилуо Ми Момиши Хэ Билгэ Жаоли хаан (爱登里罗汨设密施合毗伽昭礼可汗) хэмээн цол өргөмжлөн, 12 тэрэг зоосоор шагнав” (Lin Gan 2007: 172) хэмээн тэмдэглэжээ. Харин Хасар тэгийн цолыг түүхэн сурвалж бичгүүдэд зөрүүтэй тэмдэглэж ирсэн боловч нэрийн хувьд Жаоли хаан гэдэг нь бүх сурвалжид тодорхой гарч байна. Түүнийг хаан өргөмжилсөн бичээсийн бүрэн эх, хаадын зарлигийг тэмдэглэн үлдээсэн “Тангийн бүрэн судар” хэмээх сурвалжид байдаггүй. Гэвч Орхоны Хар балгасын НВ-2 талбайгаас илэрч олдсон гантиг чулуун дээрх хятад бичээсийн дотор Жаоли хаанд холбогдож болох хэд хэдэн тооны үг бий. Эдгээр ханз үсгүүд нь дээр өгүүлсэн 1 болон 2-р төрлийн бичээст байхгүй бөгөөд бичлэгийн тэг, хэлбэр хэмжээ, ханзны утга агуулга зэрэгт тулгуурлан бид Жаоли хаанд цол өргөмжилсөн бичээсний хэсгүүд хэмээн үзэв. Бид Жаоли хааны өргөмжлөх бичээсийн хэсгүүд байж нийт 9 ширхэг чулуун дээрх 22 ширхэг ханз утга үсгийг хамруулан үзэх саналтай байна. Дээрх 2 эхийн монгол орчуулгаас харахад цол өргөмжлөх бичээс нь эхлэхдээ Тан улсын хааны оны цол, он, сар, өдөр зэргээр эхэлж, улмаар хоёр улсын найрамдалт харилцааны тухай өгүүлж, дараа нь хааны цолыг бичиж, ямар ямар элчийг илгээсэн тухай гардаг бичлэгийн уламжлал байна. Тиймээс үгийн утга дээр үндэслэн дээрх дарааллын бичээснүүдийг хэрхэн уншсан тухай дор сийрүүлэе.

1. “維寶曆元年-wei bao li yuan nian. Чулууны нүүрэн хэсэгт “維寶曆元年-wei bao li yuan nian буюу Баолигийн тэргүүн он” гэсэн утгатай 5 ширхэг ханз үсэгтэй. Энд гарч буй Баоли -寶曆 гэдэг нь Тан улсын Жинзун хааны оны цол бол юань ниан-元年 нь тэргүүн, анхдугаар он гэсэн утгатай. Жинзун хаан нь Мүзун (穆宗) хааны ууган хүү бөгөөд 824 онд хаан эцгийг нас барьсны дараа 16 насандаа Тан улсын хаанд өргөмжлөгджээ. Тэрээр Мүзун хааны үед хэрэглэгдэж байсан хуучин оны цолыг түр хэрэглэж байгаад Чангчингийн (长庆) 4-р он буюу НТ 825 онд Баолигийн анхдугаар он болгон өөрчилжээ. Баоли хэмээх оны цол нь Тан улсын түүхэнд нийт 3 жил 1 сарын хугацаатай хэрэглэгдсэн бөгөөд үүнээс 2 жил 11 сар нь Жинзун хааны үед шууд хамаарна. Баолигийн 2-р оны (826) 12-р сард Лижэн хаан 18 насандаа нас барахад түүний дараа ор суусан өөрийн дүү Вэнзун (文宗) хуучин оны цолыг үргэлжлүүлэн авч дараа жилийн 2-р сар хүртэл хэрэглэжээ. НТ 827 оны 2-р сард Баоли хэмээх оны цолыг, Вэнзун хаан Тайхэ (太和) хэмээн өөрчилсөн байна. Үүнээс үзэхэд Баолигийн он тоолол нь 825 оны 1 сараас 827 оны 2-р сар хүртэл нийт 3 жил 2 сарын хугацаанд хэрэглэгдсэн тодорхой

байна. Тиймээс бидний хайж буй “Баолигийн тэргүүн он” нь НТ 825 он болно. Хугархайн урт 14,5 см, өргөн 2,8 см, зузаан 1,1 см, нүхний голч 0,4 см (Зураг 5-1).

2. 朕-zhen. Энэ үгийг зөвхөн хаан хүн өөрийгөө хэлэхдээ ашигладаг бөгөөд [хаан] би, өөрөө гэсэн утгатай. Өөрөөр хэлбэл Тангийн Жинзун хааныг нэрлэсэн бололтой. Хугархайн урт 4,1 см, өргөн 2,8 см, зузаан 1,1 см (Зураг 5-2).

3. 國[非] guo fei. Чулуун нүүрэн талд 國-guo улс гүрэн гэсэн утгатай үг тодорхой мэдэгдэх бол доод талд буй тэмдэгтээс харахад 非-fei гэсэн биш, эс, буруу гэсэн утгатай ханз байх боломжтой. Эдгээрийг нийлүүлж уншвал улс эс гэсэн утга гарна. Ханз үсгийг дээрээс нь алтадсан байна. Хугархайн урт 4 см, өргөн 2,8 см, зузаан 1,2 см (Зураг 5-3).

4. 囉-luo. Энэ үг ихэвчлэн Уйгурын хааны цолонд гардаг “登里羅” dengliluo эсвэл “騰里羅” tengliluo гэсэн “тэнгэрээс заяат” хэмээх үгийн төгсгөлд хэрэглэгддэг лүо хэмээх ханз юм. Уйгурын хожуу үеийн Бао И, Чундэ, Жаоли, Жансин нарын хаадын оны цолонд хэрэглэсэн байна. Түрэгээр “qut” хэмээн хэлдэг. Харин хятад үгэнд дангаар ямар нэгэн утга илэрхийлдэггүй туслах үг. Үсгийг алтаар шарсан. Хугархайн урт 5 см, өргөн 2,8 см, зузаан 1,1 см (Зураг 5-4).

5. 伽昭- ga zhao. Тус чулуун дээр буй хоёр ханз үсэг нь дээд болон доод хэсгээрээ хугарсан боловч эхнийх нь билгэ гэдэг үгийн 伽-ga, хоёр дахь нь Жаоли гэдэг үгний 昭-zhao гэсэн ханз байна. Тиймээс Жао хэмээх үг нь Чундэ хааны дүү Хасар тегин буюу Жаоли хааны нэр байх боломжтой юм. Тиймээс тус өргөмжлөх бичээсийн эзнийг шууд тодорхойлж буй тул чухал ач холбогдолтой. Хугархайн урт 4,3 см, өргөн 2,8 см, зузаан 1,1 см (Зураг 5-5).

在王福-zai wang fu эзэнд\ноёнд аз буян,河源-heyuan голын эх, 謂善-wei shan энэрэнгүй, хэлэх, 書-shu ном, 大-da их, том, 外来-wai lai гаднаас ирсэн гэсэн утгатай үгнүүдийг бид Жаоли хааны цол өргөмжлөх бичээсийн хэсгүүд хэмээн таамаглав (Зураг 5-6, 7, 8, 9, 10, 11). Мөн дээрээ ямар нэг ханз үсэггүй олон тооны хагархай хэсгүүд бий.

4-р бичээс. Нэр нь тодорхойгүй хааны өргөмжлөх бичээс.

Энэ төрөлд хамаарах бичээстэй чулууд харьцангуй цөөн тоотой ба одоогоор 4 ширхэг олджээ. Бичээст гарч буй үгнүүд сурвалжид буй хаадын зарлигийн бичигт дурдагдаагүй ба бичлэгийн тэг, үгийн утга болон хэмжээний хувьд өмнө өгүүлсэн гурван төрлийн бичээсээс ялгаатай болно. Тухайлбал, өргөний хувьд 3-3,2 см, зузаан нь 1,2-1,4 см хэмжээтэй байгаа нь бусдаасаа илүү өргөн, зузаан байна.

1. 雲-yun. 2009 онд Монгол-Германы хамтарсан

төслийн судлаачид Орхоны хөндий дэх Хархорум хотоос Өгий нуур хүртэлх талбайд хайгуул хийх явцад Хар балгасын Цайзат их хэрмийн баруун хойд хэсгээс түүвэр байдлаар нэг ширхэг олджээ (Arden-Wong 2015: 75). Дээд болон доод хэсгээрээ хугарсан цайвар шаргал өнгөтэй гантиг чулууны нүүрэн хэсэгт 雲-yun буюу өгүүлэх, хэлэх эсвэл үүл гэсэн утгатай ханз үсгийг хичээнгүй бичгийн тигээр бичсэн. Харин энэ ханзны өмнөх болон дараагийн ханз үсгийн зарим зурлагууд мэдэгдэх боловч уншигдах боломжгүй юм. Чулууны хугархай 4 см урт, 3,2 см өргөн, 1,3 см зузаан (Зураг 6-1).

2. 登里-deng li. 2016 онд НВ-2 талбайн Цитаделийн ФС 77-65 дугаар өргөөс олдсон. Чулууны нүүрэн талд 里-li гэсэн ханз үсэг тодорхой мэдэгдэх бөгөөд түүний өмнө талын ханзны хугархай хэсгээс харахад 登-deng гэсэн ханз байх боломжтой байна. Эдгээрийг нийлүүлж уншвал dengli буюу тэнгэр гэсэн утга гарна. Тэнгэр гэсэн үг нь Уйгурын бүх хаадын цолонд дурдагдсан байдаг. Чулууны хугархай хэсгийн урт 3,8 см, өргөн 3,2 см, зузаан 1,2 см хэмжээтэй (Зураг 6-2).

3. 授尚-jiao shang. Чулууны нүүрэн талд 授-jiao буюу үймээн самуун болон 尚-shang буюу эрхэм гэсэн утгатай хоёр ханз үсгийг сийлсэн байна. Чулууны хугархай 5,1 см урт, 3,1 см өргөн, 1,4 см зузаан (Зураг 6-3).

4. 特-te. Нүүрэн талд 特-te буюу онцгой гэсэн утгатай нэг ширхэг ханз утга үсэгтэй. Энэ үг 1 болон 2-р бичээсийн эхэд байхгүй бөгөөд хэмжээний хувьд бага зэргийн өргөн тул 4-р төрөлд оруулсан болно. Хугархайн урт 3,1 см, өргөн 2,9, зузаан 1 см (Зураг 6-4).

5. Энэхүү чулууны нүүрэн талдаа ямар нэг ханз үсэггүй ба цуулдасны хамгийн дээд хэсгийн хугархай юм. Учир нь хажуу талдаа 0,5 см голчтой дугуй хэлбэрийн хэлхэ хүхтэй. Чулууны хугархайн хадгалагдсан ургын хэмжээ 4,1 см, өргөн 3,1 см, зузаан 1,1 см (Зураг 6-5).

Дүгнэлт

Уйгурын хаант улсын нийслэл Хар балгасын Ордон хотын туриас илэрч олдсон гантиг чулуун дээрх 1, 2, 3-р бичээсүүд нь Чундэ (821), Жаоли (825) гэсэн Эдиз овгийн хоёр хааны цол өргөмжилсөн гурван бичээс байна. Харин 4-р төрлийн бичээс дээр тодорхой он, хааны нэр байхгүй тул яг ямар хааных болохыг шууд хэлэх боломжгүй боловч тэнгэр гэсэн хааны цол байгаа нь өргөмжлөх бичээс мөн болохыг илтгэнэ. Бидний таамаглаж буйгаар Уйгурын Яклагар овог доройтон унасны дараагаар Эдиз овгийн хаад, хаан ширээг залгамжлан авсан ба Кутлуг (795), Күлүг Билгэ (805), Бао И (808) зэрэг хаадын аль нэгийг өргөмжлөх бичээс байх боломжтой. Учир нь Кутлуг

Бойла хаанаас Ачор хаан хүртэл Уйгурын төрийг Яклагар овгийн 6 хаад ээлжлэн захирч байсан бөгөөд тэдний ноёрхол 795 онд төгсөж, улмаар Эдиз овогт хаан ширээ шилжсэн болохыг Чан Ань хотын орчмоос олдсон Харичор тегиний бунхны бичээст тулгуурлан гаргажээ (Мөрөн, Анхбаяр 2015: 15). Хятад сурвалжид Уйгурын бусад олон хаадын цол өргөмжлөх бичээс байдаггүй ба Хар балгасын малтлагаас биет байдлаар бичээсийн хэсгүүд олдсон явдал нь цаашид Уйгурын хаант улсын хожуу үеийн түүхийн судалгаанд бичгийн үнэт эх сурвалж болох нь эргэлзээгүй юм.

Тан улсын үеийн зарлигийн бичээсүүд нь дөрөв болон зургаан үсгийн хослолоос бүтсэн зохиомжтой бөгөөд бичгийн эхэн хэсэгт хаадын оны цол, жил, сар, өдөр, хоёр дахь хэсэгт хааны хэлсэн үг болон учир шалтгаан, гурав дахь хэсэгт Уйгурын хааны гавьяа зүтгэлийг сайшаан магтаж цол өргөмжлөх, дөрөв дэх хэсэгт зэрэг хэргэмийг дагах болон бичиг явуулсан элч, шагнал зэргийг тодорхой өгүүлсэн байна. Хаадын цол өргөмжлөх бичээс олдсон Хар балгасын Цитаделийн барилгыг Монгол-Германы Орхон экспедиц 2010-2018 оны хооронд малтан судалж энэхүү барилгын үүрэг зориулалтыг Уйгурын нийслэлийн Ордон хотын маш чухал газар хэмээн үзэж байна. Бичээст гарч буй зарим үгс Уйгурын хааны нэр болон цол байгаагаас үзвэл лавтай хаад язгууртан нарт зориулсан чухал эд зүйлсийг хадгалж байсан хааны ордны хэсэг байх өндөр магадлалтай.

Abstract

CORONATION LETTERS TO UYGHUR KHANS FROM KARABALGASUN, ORKHON VALLEY

by Damchaabadgar Sodnomjamts, Ulambayar Erdenebat, Christina Franken, Tumur-Ochir Batbayar and Hendrik Rohland

Material culture from archaeological excavations along with textual records form the basis for a better understanding of Nomadic steppe empires of the Middle Ages and their intercultural contacts. The Mongolian-German Orkhon Expedition (MONDOREx) retrieved a fascinating collection of artefacts in Karabalgasun, the former capital of the Uyghur Empire (744/745-840). Among these artefacts, remnants of “jade books” were discovered. They are considered royal decrees for the coronation of Uyghur khans. These strips of stone are polished and inscribed with Chinese calligraphy, with the incised letters covered in gold. Originally, several of these strips were held together with gold wire, giving them the appearance of a traditional Chinese bamboo scroll. Chinese emperors used these precious gemstone scrolls

during significant rituals. The discovery of these artifacts in Karabalgasun (Ordubaliq) highlights the strong affiliation between the Uyghur rulers and the Chinese imperial authority. This also bolsters the notion that the citadel held a significant political role, potentially as the Uyghur ruler's palace.

A total of 46 marble fragments with Chinese text were uncovered at the HB2 excavation location in the palace precinct of Karabalgasun. After examining the written sources detailing the history of East Asia in the 8th and 9th centuries, it is apparent that the Tang dynasty of China sent "title letters" to confirm the authority of their political partners, the Uyghurs.

Analysis of Chinese inscriptions on these marble stones revealed four different inscription stages which vary by inscription size, content, and writing style. These include 1) letter for crowning Ch'ung-te as khan (821), 2) letter for re-crowning Ch'ung-te as khan (821), 3) letter for crowning Zhao-li as khan (825), and 4) letter for crowning an unknown individual as khan.

The Karabalgasun citadel, where these inscriptions were discovered, underwent excavation between 2010 and 2018 under the auspices of the Mongolian-German Orkhon Expedition. The inscriptions repeatedly mentioning the names and titles of Uyghur khans indicate that the building complex was likely the royal palace. It is probable that the complex also served as an archive for important artefacts from the reign.

Keywords: Orkhon Valley, Uyghur Empire, Ordubaliq, Karabalgasun, jade books, coronation letters, Tang dynasty

Ном зүй

Азаяа, Б. (2013). Орхон бичгийн дурсгал V (Моюнчурын гэрэлт хөшөө). - Улаанбаатар.

Болд, Л. (2011). Орхон бичгийн дурсгал IV (Күл-тегиний бичээс). - Улаанбаатар.

Мөнхтулга, Р. (2017). Уйгур улс 744-840 он. - Монголын эртний түүх. IV боть: Түрэг, Уйгур. Ботийн редактор А.Энхтөр. - Улаанбаатар, 196-202.

Мөрөн, Б., Анхбаяр, Б. (2015). Харичор тегиний бунхны бичээс хийгээд Уйгурын Яклагар овогтны доройтол. - Эртний Түрэгийн түүх, соёл олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. - Улаанбаатар, 5-15.

Тэцу Масумото (1996). О фрагментах мраморных табличек с иероглифами, найденных в окрестностях города Абакана в Южной Сибири. Археология, Антропология и Этнография Сибири. - Барнаул, 207- 220.

Цэвэл, Я. (1966). Монгол хэлний товч тайлбар толь. - Улаанбаатар.

Эрдэнэбат, У. (1997). "Монголын Нууц Товчоо"-ны

Алан Гоа эхийн домгийн учир (Түүх, угсаатны зүйн найруулал). - Улаанбаатар.

Эрдэнэбат, У. (2018). Уйгурын эзэнт гүрэн. - Монголчууд: Талын нүүдэлчдийн уламжлал (Нэн эртнээс XII зууны эхэн). Монсудар, - Улаанбаатар, 156-179.

Эрдэнэбат, У., Содномжамц, Д. (2016). Уйгурын Хар балгасаас олдсон нүүр ваарны төрөл, хээ чимэглэлийн тухай. - Mongolian Journal of Anthropology, Archaeology and Ethnology. Vol. 9, No 1 (471). - Улаанбаатар, 73-84.

Ai Jinjing., Zhao Fusheng (1991). 袁进京, 赵福生 《北京丰台唐史明墓》, 《文物》1991年9期。

Arden-Wong, L.A. (2015). Preliminary Thoughts on the Marble Inscriptions from Karabalgasun". in: Journal of Inner Asian Art and Archaeology 6, 75-100.

Cun Mingde (2005). 崔明德 《中国古代和亲史》 人民出版社2005年339-340页

Fan Yingfeng, Bai Genxing (2006). 樊英峰, 拜根兴. 《唐懿德太子哀册文关联问题述论》, 《乾陵文化 研究》, 2006年00期, 247-256页.

Franken, Ch., Erdenebat, U., Batbayar, T. (2014). Erste Ergebnisse der Grabungen des Jahres 2013 in Karabalgasun und Karakorum, Mongolei. in: Zeitschrift fuer Archaeologie Aussereuropaeischer Kulturen. Band 6, Reichert Verlag. - Wiesbaden, 355-372.

Franken, Ch., Rohland, H., Erdenebat, U. (2017). Aktuelle Ergebnisse der archaologischen Forschungen in den spaetnomadischen Stadtanlagen Karabalgasun und Karakorum im mongolischen Orchontal. -in: Zeitschrift fuer Archaeologie Aussereuropaeischer Kulturen. Band 7, Reichert Verlag. - Wiesbaden, 385- 402.

Franken, Ch., Rohland, H., Erdenebat, U., Batbayar, T. (2018). Karabalgasun, Mongolei. Die Ausgrabungen im Bereich der Zitadelle der alten uighurischen Hauptstadt. Die Arbeiten der Jahre 2015 bis 2017. in: Forschungsberichte des DAI 2018, Faszikel 2, - Berlin, 99-105.

Franken, Ch., Rohland, H., Erdenebat, U., Batbayar, T. (2019). Karabalgasun – The Uyghur capital in the Orkhon Valley, Mongolia. in: Excavated Worlds: 40 years of archaeological research on four continents. Commission for the Archaeology of Non-European Cultures. Deutsches Archaeologisches Institut, KAAK, - Bonn, 136-145.

Franken, Ch., Rohland, H., Erdenebat, U., Batbayar, T. (2020). A cradle of Civilisations: Excavating Nomadic Capital Cities in Mongolia. in: Current World Archaeology, Issue 99, February / March 2020, 24-30.

Fu Xinglin (2006). 付兴林 《白居易散文研究》 陕西师范大学博士学位论文。

Huettel, H.-G., Erdenebat, U. (2009). Karabalgasun und Karakorum – Two late nomadic urban settlements in the Orkhon Valley. Archaeological Excavation and Research of the German Archaeological Institute (DAI) and the Mongolian Academy of Sciences 2000-2009. - Ulaanbaatar.

Gong Yin (2000). 龚荫 《唐代和亲政策述论》 云南大学人文社会科学学报2000年第1期第26 卷。 Kaogu

(2023). 陕西省考古研究院(陕西考古博物馆)《考古圣地 华章陕西 - 陕西考古博物馆基本陈列》, 三秦出版社2023年。

Lin Gan (2007). 林幹《突厥与回纥史》内蒙古人民出版社, 2007年, 172页。

Lin Sixian (2012). 林恩显《中国古代和亲研究》黑龙江教育出版社2012年, 300页。

Ren Jiang (2007). 任江《略论唐宋玉册官制度——以碑志资料为中心》四川文物2007年第6期, 45页。

Rohland, H., Franken, Ch., Erdenebat, U., Batbayar, T. (2023). Karabalgasun and Karakorum: Nomad cities as Means of Communication between Nomad Elites and the Multicultural Subjects. – Acta Mongolica. Special Issue : Dispersed & Connected. Mobilities, Materialities and Belonging(s) in Mongolia and beyond. Vol. 21 (541). – Ulaanbaatar, 11-50.

Toepfer, T., Franken, Ch., Rohland, H., Hutterer, R.,


Erdenebat, U., Batbayar, T. (2023). A Gyrfalcon *Falco rusticolus* from an Uyghur well in Karabalgasun (Ordu-Baliq), Central Mongolia. in: Journal of Global Archaeology, Vol. 6, Deutsches Archaeologisches Institut, Kommission fuer Archaeologie Ausseuropaeischen Kulturen. - Bonn, 180-203. DOI: 10.34780/6yl9-i26c

Wang Yikang (2018). 王义康《唐代册封与授受四夷官爵试探》清华大学学报, 2018年第3期。


Wang Yulong, Cheng Ruiping, (2003). 王育龙、程蕊萍.《唐代哀册发现述要》,《文博》1996年第6期, 51-55页。

《旧唐书》, 卷一九五《回鹘传》。


《唐大诏令集》卷一百二十九 :册册回鹘可汗文、册回鹘可汗加号文。《全唐文》, 卷666:白居易:册新回鹘可汗文、册回鹘可汗加号文。




Зураг 1. Монгол Улс, Архангай аймаг, Хотонт сум, Уйгурын Хар балгасын Ордон хот.
Цол өргөмжлөх бичээс илэрсэн цитадель



Зураг 2. 1-р төрлийн бичээс: Хар балгасын Ордон хотоос олдсон Чундэ хаанд шинээр цол өргөмжилсөн бичгийн хэсгүүд. 1. 北之氣-bei zhi qi (HB2\2018No001), 2. 較雄-jiao xiong (HB2\2011No4245), 3. 不德-bu de (HB2\2018No59), 4. 咨尔-zi er (HB2\2017No278), 5. 君登-jun deng (HB2\2017No279), 6. 使朝-shichao (HB2\2016No326), 7. 兼少-jianshao (HB2\2017No280), 8. 備物-beiwu (HB2\2014No417), 9. 於戲善必-wuhu shan bi (HB2\2018No53)




Зураг 3. 2-р төрлийн бичээс: Хар балгасын Ордон хотоос олдсон Чундэ хаанд цол нэмж өргөмжилсөн бичгийн хэсгүүд 1. 若曰-ruo yue (HB2\2016No109), 2. 北方-bei fang (HB2\2017No30), 3. 沒密施-mo mi shi (HB2\2015No316), 4. 於天下氣無-yu tian xia qi wu (HB2\2018No69), 5. 仍舊姻-reng jiu yin (HB2\2015No016), 6. 柔遠為-rou yuan wei (HB2\2015No339), 7. 於 - wu hu (HB2\2016No188), 8. 始終-shi zhong (HB2\2017No032)



Зураг 4. Чундэ хаанд цол нэмж өргөмжилсөн бичгийн бүрэн эх
《唐大詔令集》卷一百二十九

Зураг 5. 3-р төрлийн бичээс: Хар балгасын Ордон хотоос олдсон Жаоли хааны цол өргөмжилсөн бичгийн хэсгүүд. 1. “維實曆元年-wei bao li yuan nian (HB2\2016No67, 327), 2. 朕-zhen (HB2\2016No300), 3. 國非-guo fei (HB2\2016No012), 4. 囉-luo (HB2\2016No61), 5. 伽昭-ga zhao (HB2\2016No15), 6. 在王福-zai wang fu (HB2\2016No002, 034), 7. 河源-heyuan (HB2\2016No016), 8. 謂善-wei shan (HB2\2015No248), 9. 書-shu (HB2\2015No559), 10. 大-da (HB2\2015No75), 11. 外来-wai lai (HB2\2017No019)



Зураг 6. 4-р төрлийн бичээс: Хар балгасын Ордон хотоос олдсон нэр нь тодорхойгүй хааны өргөмжлөх бичгийн хэсгүүд. 1. 雲-yun (HB\2009), 2. 登里-deng li (HB2\2016No072), 3. 校尚-jiao shang (HB2\2016No133), 4. 特-te (HB2\2016No011), 5. 尙-shang (HB2\2017No033)

